

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

**Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс,
төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**


(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

| Д/д | Шийдвэр гаргагч | Шийдвэрийн огноо | Шийдвэрийн дугаар | Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх | Шийдвэрийн хуулбар |
|-----|---------------------|------------------|-------------------|---|--------------------|
| 1 | Аймгийн Засаг дарга | 2023.03.16 | A/92 | Хөрөнгө зарцуулах тухай | |
| 2 | Аймгийн Засаг дарга | 2023.03.13 | A/100 | Дэмжлэг үзүүлэх тухай | |

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга

Холбогдох утас: 70384096, 88089938

И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn





МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/100

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүүгийн дэмжлэг хүссэн мөрөн сумын иргэн Л.Балдандоржид 150,000 төгрөг, мөрөн сумын иргэн Н.Дамдинд 1,000,000 төгрөг дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.
2. Дээрх зардлын 1,150.000 (Нэг сая нэг зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны иргэд байгууллагаас ирсэн санал шийдвэрлэх зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.
3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

2006-83115-210907

6712013401



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/92

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Их Хурлын 2021 оны 103 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит бус XIII дугаар хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ сэргэлтийн бодлого”, “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтыг хангах, “Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага”-ыг дэмжих ажлын хүрээнд “Нээлттэй-Хөвсгөл” сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зардалд 5.040.000 (таван сая дөчин мянга) төгрөг, Улаанбаатар хотод зохион байгуулагдах “Хөдөөгийн сэргэлт” чуулганд оролцож аймгийн онцлог, давуу тал, шилжин суурьшигчдыг хүлээн авах бодлого төлөвлөгөө танилцуулж, хотоос хөдөө рүү шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн танилцуулга хийх, иргэд, олон нийтээс сонирхсон асуултад хариулт өгч мэдээлэл хүргэх үйл ажиллагааны зардалд 5.289.520 (таван сая хоёр зуун наян есөн мянга таван зуун хорь) төгрөг, нийт 10.329.520 (арван сая гурван зуун хорин есөн мянга таван зуун хорь) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 10.329.520 (арван сая гурван зуун хорин есөн мянга таван зуун хорь) төгрөгийг Засаг дарга дансны “Төсөл арга хэмжээний бэлтгэл хангах зардал”-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6710010095